

037.

30

**ШАРЫНГОЛ ХУВЬЦААТ КОМПАНИ**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН МАТЕРИАЛ**

№ ...

**20 15 ОНЫ 4 САРЫН 30 ӨДӨР**

**“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн  
ээлжит хурлын үйл ажиллагааны дараалал**

2015.04.30

д/д	Үйл ажиллагаа	Хариуцагч
1	Хуралд оролцох хувьцааг бүртгэж нэгтгэн, мэдээлэл бэлтгэх	Тооллогын комисс Л.Эрхбаатар
2	ХЭ-ийн хуралтай холбогдсон төлөвлөгөө, гүйцэтгэл танилцуулах	ТУЗ-ийн н/б дарга Л.Батсуурь
3	Хуралд ирсэн хувьцааны бүртгэлийн дүн бүхий мэдээлэл танилцуулах	Тооллогын комисс Л.Эрхбаатар
4	ХЭ-ийн хурал нээх	Хурлын дарга Б.Батмөнх
5	ХЭ-ийн хуралд хэлэлцэх асуудал, дотоод журмыг танилцуулах	Хурлын дарга Б.Батмөнх
6	Компанийн 2014 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тайлан	Гүйцэтгэх захирал Б.Батбаатар Инженер Ж.Эрдэнэбат
7	Компанийн 2014 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын дүгнэлт	Гүйцэтгэх захирал Б.Батбаатар Ерөнхий ня-бо Л.Даваасүрэн Эдийн засагч Л.Оюундарь
8	ТУЗ-ийн тайлан бүхий дүгнэлт	ТУЗ-ийн н/б дарга Л.Батсуурь
9	Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 250 дугаар тогтоолын дагуу олон нийтэд санал болгосон үнэт цаасны тухай	Гүйцэтгэх захирал Б.Батбаатар
10	ТУЗ-ийн 2015 оны зардлын төсөв	Хурлын дарга Б.Батмөнх
11	Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэртэй холбогдсон танилцуулга	Хурлын дарга Б.Батмөнх Эдийн засагч Л.Оюундарь
12	Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох	Хурлын дарга Б.Батмөнх Тооллогын комисс Л.Эрхбаатар
13	Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон ХЭ-ийн асуулт хариулт, санал бодол	Хурлын дарга Б.Батмөнх
14	Завсарлага, санал тоолох	Тооллогын комисс Л.Эрхбаатар
15	Санал хураалтын дүнг хуралд оролцогчдод танилцуулах /тооллогын комиссын тогтоол/	Тооллогын комисс Л.Эрхбаатар
16	ХЭ-ийн хурлаас гарах тогтоолыг танилцуулж батлуулах	ТУЗ-ийн н/б дарга Л.Батсуурь
17	Хурал хаах	Хурлын дарга Б.Батмөнх

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТМӨНХ

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2015.4.30

№ 01

Улаанбаатар

“Шарын гол”ХК-ий хувьцаа эзэмшигчдийн хурал 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 16<sup>10</sup> цагт “Корпорейт зочид буудал” ХХК-ийн хурлын танхимд эхэлж 18<sup>20</sup> цагт дуусав.

Хурлын эхэнд компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбогдсон хийгдэх ажил, цаг хугацааны графикчилсан төлөвлөгөөний гүйцэтгэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Батсуурь танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирсэн саналын хуудсаар хуралд оролцогчдын ирцийг тооллогын комисс /Л.Эрхбаатар/ нэгтгэн гаргалаа.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд нийт 10.231.389 ширхэг энгийн хувьцаанаас 10.170.242 ширхэг саналын эрхтэй хувьцааг төлөөлж 9.532.144 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч буюу 93,7 хувь нь хуралд ирсэн учир хурлын ирцийг хангалттай гэж үзэж байгаа гээд уг хуралд санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан тайлбар өгөн, тооллогын комиссын мэдээллийг тооллогын комиссын дарга Л.Эрхбаатар уншиж сонсгоод хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье гэв.

Хурлыг нээж, хурлын дарга Б.Батмөнх үг хэлж, хуралд хэлэлцэх асуудал, хурлын дотоод дэгийг танилцуулав.

**Б.Батмөнх** – Компанийн ТУЗ-ийн хурлаас, ХЭ-ийн хурлын даргаар намайг томилсон.

Энэхүү хурлын эхэнд Хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбогдон хийх ажлын цаг хугацааны графикчилсан төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын гүйцэтгэлийг дэлгэрэнгүй танилцууллаа. ТУЗ-ийн хурлаар томилсон тооллогын комисс, өнөөдрийн хурлын ирцийг гаргаж мэдээллээ. Хурлын ирц хангалттай байгаа тул хурлын үйл ажиллагааг нээж байна гэв.

ХЭХ-ын хэлэлцэх асуудал, дотоод дэг журам болон тайлан, хурлаас гарах шийдвэрийн төсөл зэрэг бүх материалыг манай хувьцаа байгаа брокер диллерийн компаниудаар урьдчилан танилцах боломжийг бүрдүүлсэн гэв.

Өнөөдрийн хуралд дараахь асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргана. Үүнд:

1. Компанийн 2014 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн тайлан бүхий дүгнэлт, ТУЗ-ийн тайлан
2. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 250 дугаар тогтоолын дагуу олон нийтэд санал болгосон үнэт цааснаас арилжаалагдаагүй хувьцааг хасах тухай
3. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

4. Компанийн ТУЗ-ийн 2015 оны цалин урамшуулал, зардлын төсвийг батлах

Эдгээр асуудлаар санал хурааж шийдвэр гаргах бөгөөд компанийн ногдол ашиг хуваарилаагүй талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулна.

Хурлын дотоод дэг журамд заасан асуудал бүрээр цаг хугацааг төлөвлөсөн байгаа гэв.

Өнөөдрийн хуралд компанийн ТУЗ-ийн гишүүн Д.Байлхүү, Жеймс Пассин, Ж.Батболд болон гүйцэтгэх удирдлагын баг болох гүйцэтгэх захирал Б.Батбаатар, дэд захирал Л.Эрхбаатар, Б.Отгонзул, ерөнхий нягтлан бодогч Л.Даваасүрэн, эдийн засагч Л.Оюундарь, үйлдвэрлэл эрхэлсэн орлогч Ж.Эрдэнэбат бусад хүмүүс оролцож байна гэв.

Хуралд хэлэлцэх асуудал хурлын дэгийг танилцуулав.

**1. ХЭЛЭЛЦСЭН НЬ:** “Компанийн 2014 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын тайлан “

**Б.Батмөнх** – Энэхүү тайланг хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулан хэвлэж та бүхний гар дээр хүргүүлсэн товхимолд бүрэн байгаа. Компанийн 2014 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тайланг компанийн үйлдвэр эрхэлсэн орлогч Ж.Эрдэнэбат танилцуулна гэв.

**Ж.Эрдэнэбат** – Уг тайланг дэлгэц ашиглан маш дэлгэрэнгүй тайлбарлав. /Материалыг хурлын материалд хавсаргав/

**Б.Батмөнх** → Асууж тодруулах санал бодлоо ярих асуудлыг тайланг бүрэн сонссоны дараа хийе гээд одоо компанийн 2014 оны санхүүгийн тайланг эдийн засагч Л.Оюундарь танилцуулна гэв.

**Л.Оюундарь** – Компанийн 2014 оны санхүүгийн тайланг дэлгэц ашиглан дэлгэрэнгүй тайлбарлан яриу. /Материалыг хавсаргав/

**Б.Батмөнх** - Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын тайлан болон ТУЗ-ийн 2015 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 05 дугаар тогтоолоор үнэлэлт дүгнэлт өгсөн “Компанийн 2014 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулав. /Материалыг хавсаргав/

**2. ХЭЛЭЛЦСЭН НЬ:** “Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 250 дугаар тогтоолын дагуу олон нийтэд санал болгосон үнэт цааснаас арилжаалагдаагүй хувьцааны тухай”

**Б.Батмөнх** – Манай компани 2011 онд нэмэлт хувьцаа гаргасан юм. Үүнээс арилжаалагдаагүй үлдсэн 61.147 ширхэг энгийн хувьцаа одоо хүртэл тусгаарлагдсан хэлбэрээр бүртгэлд байна.

Энэ асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 2 дугаар сарын 06-ны хуралд хэлэлцээд бүртгэлээс хасуулах саналыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулан хэлэлцүүлж шийдвэрлүүлэх нь зүйтэй гэсэн тогтоол гаргасан юм.

Энэхүү тогтоолыг өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын материалд оруулан та бүхэнд хүргэсэн товхимолд нийтэлсэн байгаа. Энэ асуудлаар саналын хуудсаар санал хураах тул та бүхэн саналаа өгөөрэй.

Гол нь энэ асуудалтай холбогдон компанийн дүрэмд өөрчлөлт орох тул үүгээр эцэслэн шийдсэн тухай тогтоол гаргах болно гэв.

**3. ХЭЛЭЛЦСЭН НЬ:** “Компанийн ТУЗ-ийн гишүүдийн 2015 оны цалин урамшуулал зардлын төсвийг батлах тухай”

**Б.Батмөнх** – Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн болон үйл ажиллагааны зардлыг өнгөрсөн жилийнхээс өсгөөгүй. Тэр хэмжээнд төлөвлөсөн байгаа.

Уг зардалд цалин хөлснөөс гадна нийгмийн даатгалын шимтгэл, шуудан холбооны зардал, бичиг хэрэг, томилолтын зардал, түлш шатахуун, хурлын зардал, зар сурталчилгаа бусад төрлийн зардал бүгд багтдаг гээд нэг бүрчлэн танилцуулав.

Зардлын төсвийг хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан товхимолд нийтэлсэн учир та бүхэн танилцсан байгаа байх гэв.

**4. ХЭЛЭЛЦСЭН НЬ:** “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай”

**Б.Батмөнх** – Компанийн ТУЗ-ийн гишүүдийн хугацаа дуусч өнөөдөр шинээр сонгох учир нэр дэвшүүлэхээр санал ирүүлсэн хүмүүсийн товч намтар бүхий танилцуулгыг энэ хуралд зориулж хэвлэсэн товхимолд нийтлүүлсэн тул та бүхэн танилцсан байх. Тэднээс асууж тодруулах зүйл байвал асууж танилцана уу гэв.

Асуулт асуусан хүн байсангүй.

**5. ХЭЛЭЛЦСЭН НЬ:** “Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах”

**Б.Батмөнх** – Энэ асуудлаар санал хураахгүй, зөвхөн танилцуулах тул ТУЗ-ийн шийдвэр бүхий тогтоолыг эдийн засагч Л.Оюундарь танилцуулж тайлбар хийнэ гэв.

**Л.Оюундарь** – Өнгөрсөн жил уулын ажлын хүндрэл нилээд байсан тул хөрс хуулалтыг ахиу явуулснаар нүүрс олборлолт төлөвлөсөн хэмжээндээ хүрээгүй.

Мөн тоног төхөөрөмжийн шинэчлэл болох нүүрс баяжуулах үйлдвэр, Нако түлшний үйлдвэрт нилээд хэмжээний хөрөнгө оруулалт хийгдсэн. Шинээр машин техник төлөвлөгдсөн хэмжээнд авах шаардлагатай байсан зэргээс бид 3,6 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан гэдгийг өмнөх тайландаа дэлгэрэнгүй танилцуулсан.

Дараа нь ТУЗ-ийн тогтоолыг уншиж танилцуулав.

**Б.Батмөнх** – Хуралд хэлэлцэх асуудлыг бид бүрэн танилцууллаа. Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон асуулт, санал бодлоо хурлын дотоод дэгийн хугацааг баримтлан чөлөөтэй ярилцахыг хүсье гэв.

**Б.Цэрэнжав** /хувьцаа эзэмшигч/

1. Баяжуулах үйлдвэрийн талаар мэдээлэл сонсьё. Учир нь баяжуулсан нүүрсээ болон ердийн нүүрсийг дотооддоо дулааны станцуудад хямд өгөх ямар шаардлагатай юм бэ?

2. Нако түлшний талаар бас мэдээлэл авмаар байна. Энэ үйлдвэр бидэнд ашиг өгөх үү гэв.

**Б.Батмөнх** – Баяжуулах үйлдвэрийг бид авснаар нүүрсний чанарыг сайжруулан илүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болох нүүрсийг гаргаж дотоодын хэрэглэгчдэд нийлүүлэх, улмаар гадаадад гаргах зорилготой юм.

Жилдээ 600,0 мянган тонн нүүрс баяжуулах бөгөөд компанид үр ашгаа өгнө гэж тооцоолсон байгаа. Эхлээд 20,0 мянган тонн нүүрсийг Солонгост гаргана.

Нако түлшний хувьд утаагүй түлш үйлдвэрлэж төвийн хэрэглэгчдэд нийлүүлэх зорилготой авсан. Утаагүй түлш авах үндсэн сан хоосорсон учир бид төвийн районд нийлүүлэлт хийж чадахгүй Дарханыг хангах зорилгоор ажиллана.

Энэ бол ашиггүй үйлдвэр биш. Алсыг харж байна. Шарын голын нүүрсээр Дархан, Эрдэнэтийг хангахаас аргагүй. Энэ нь бидний гол зах зээлээс гадна засгийн бодлогыг бодох ёстой.

Бид 2 станцаас гадна Хөтөлийн цементийн үйлдвэр, Төмөрлөгийн үйлдвэртэй гэрээ байгуулж нүүрс нийлүүлнэ.

**Б.Цэрэнжав** – Хувьцааны ханш унаад байна. Мөн компани алдагдалгүй ажиллах боломж хэр вэ?

**Б.Батмөнх** – Хувьцааны ханшийн уналт зөвхөн манай компани биш нийтийг хамарч байгаа байх. Учир нь Монголын эдийн засагтай холбоотой. Тиймээс хувьцааны эрэлт буурч ханш нь унаж байгаа байх.

**Б.Батбаатар** – 2014 онд алдагдалтай байгааг тайланд дэлгэрэнгүй тусгаж тайлбарласан. Хамгийн гол нь үндсэн мөргөцөгт хөрс хуулалтыг илүү явуулсан юм.

Шаазгайтын ордыг нээнэ. Гэхдээ үндсэн мөргөцөгт нүүрс олборлолтыг ахиу хийнэ. Эндээс чулуулгийн хольц ихтэй нүүрс олборлох тул бид баяжуулах үйлдвэрийг яаравчлан байгуулж байгаа юм.

Дараа дараачийн жилээс хөрс хуулалтын коэффициент буурна.

Нүүрс олборлолтыг нэмэгдүүлсэн тохиолдолд ашигтай ажиллах нөхцөл бүрдэнэ гэв.

**П.Нямдорж** /хувьцаа эзэмшигч/ - Нүүрсний өөрийн өртөг яагаад өндөр байна вэ?

Үнэ чөлөөлж болохгүй юу?

**Б.Батмөнх** – УИХ-ын 72 дугаар тогтоолоор 2013 оноос үнэ чөлөөлөхөөр байсан боловч чөлөөлөөгүй.

Энэ оны 7 сарын 1-ээс эрчим хүчний үнийг чөлөөлнө гэсэн. Үүнтэй уялдаад нүүрсний үнийг индексжүүлэх байх.

Өнөөдөр манайд эрчим хүчний үйлдвэрээс өөр нүүрс нийлүүлэх зах зээл бага байна.

Дарханы ДЦС-д Германы зээлээр өргөтгөл хийгдэж байна. Өргөтгөл дуусвал нүүрснийг илүү нийлүүлнэ.

Хөтөл, Төмөрлөгийн үйлдвэрт нүүрс нийлүүлж, баяжуулсан нүүрсийг гадаад зах зээлд гаргаад ирсэн үед байдал өөр болно гэж өөдрөгөөр тооцоолж байгаа шүү.

Өөр асуулт, санал бодол гаргах хүн байсангүй.

Хэлэлцэх асуудал дууссан тул тооллогын комиссын дүн, шийдвэр гарах хооронд цайны түр завсарлага 20 минут болов.

Хурлын тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсаар ирүүлсэн саналыг тоолж нэгтгэсэн тул хурал үргэлжлэв.

Тооллогын комиссын дарга Л.Эрхбаатар тооллогын комиссын дүн, тогтоолыг танилцуулав. Үүнд: Нийт 24 саналын хуудас бүхий 9.532.259 ширхэг энгийн хувьцааны санал ирснээс саналын 8 хуудас бүхий 115 ширхэг энгийн хувьцаа хүчингүйд тооцогдож саналын 16 хуудас бүхий 9.532.144 эрхтэй саналын хуудасыг хүчинтэйд тооцлоо гэв.

Тус хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрийг зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн саналын тоо, хувь, тооллогын комиссын тогтоол дугаар 1, 2, 3, 4-ийг уншиж танилцуулав. Үүнд:

д/д	Хэлэлцсэн асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Хувь	Баталсан шийдвэр
1.	Компанийн 2014 оны үйдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, ТУЗ-ийн ажлын тайлан	9.532.144			100%	Тооллогын комиссын тогтоол дугаар 01
2.	Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 250-р тогтоолын дагуу олон нийтэд санал болгосон үнэт цааснаас арилжаалагдаагүй хувьцааны тухай	9.532.144			100%	Тооллогын комиссын тогтоол дугаар 02
3.	Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох					Тооллогын комиссын тогтоол дугаар 03
	<b>Ердийн гишүүд:</b>					
	Б.Батмөнх	8.330.493			14.57%	
	Б.Батбаатар	8.330.493			14.57%	
	Ж.Батболд	15.540.629			27.17%	
	Грам Чапман	8.330.433			14.57%	
	Д.Даянбилгүүн	8.330.433			14.57%	
	Жеймс Пассин	8.330.433			14.57%	
	<b>Хараат бус гишүүд:</b>					
	Д.Байлхүү	11.935.566			41.74%	
Жозеф Найэми	8.330.433			29.13%		
Кеннет Фаррелл	8.330.433			29.13%		
4.	Компанийн ТУЗ-ийн гишүүдийн 2015 оны цалин урамшуулал, зардлын төсвийг батлах	9.532.144			100%	Тооллогын комиссын тогтоол дугаар 04

Тооллогын комиссын тогтоолоос асууж танилцах зүйл гарсангүй. /Тооллогын комиссын тогтоолуудыг хавсаргав/



## ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хэлэлцсэн асуудалтай холбогдуулан гарах тогтоолуудын төслийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Батсуурь уншиж сонгов. Үүнд:

1. “Компанийн 2014 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, ТУЗ-ийн ажлын тайлангийн тухай” Тогтоол № 01.
2. “Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 250-р тогтоолын дагуу олон нийтэд санал болгосон үнэт цааснаас арилжаалагдаагүй хувьцааны тухай” Тогтоол № 02.
3. “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай”  
Ердийн гишүүнээр:  
Б.Батмөнх  
Б.Батбаатар  
Ж.Батболд  
Грам Чапман  
Д.Даянбилгүүн  
Жеймс Пассин нарыг  
Хараат бус гишүүнээр:  
Д.Байлхүү  
Жозеф Найэми  
Кеннет Фаррелл нарыг сонгосон. Тогтоол №03.
4. “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2015 оны цалин урамшуулал, зардлын төсвийн тухай” Тогтоол № 04.

Эдгээр болно. /Тогтоолуудыг хавсаргав/

Хурлаас гарах тогтоолын төслийн талаар асууж тодруулах зүйл байгаа эсэхийг хурал даргалагч Б.Батмөнх асуухад асуулт гарсангүй.

Хурлын үйл ажиллагааг хурлын дарга Б.Батмөнх хааж, товч үг хэлснээр хурлын ажиллагаа өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн : Нарийн бичгийн дарга

Л.Батсуурь

Танилцсан: Хурлын дарга

Б.Батмөнх

